



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2015 оны 11 сарын 13 өдөр

Дугаар 1692

Улаанбаатар хот

Загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, 16 дугаар зүйлийн 16.3, 16.4, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:


1. Улсын бүртгэлийн ерөнхий газрын салбар, нэгжийн тугны загварыг 1 дүгээр хавсралтаар баталсугай.
2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газрын дарга С.Алтангэрэлд үүрэг болгосугай.
3. Энэхүү тушаалыг 2015 оны 11 дүгээр сарын 11-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ДАРГА



Ц.ПҮРЭВДОРЖ

Улсын бүртгэлийн ерөнхий газрын
даргын 2015 оны 42 дугаар
тушаалын 1 дүгээр хавсралт



Улсын бүртгэлийн ерөнхий газрын салбар, нэгжийн тугны дэвсгэр өнгө нь өнө мөнхөд, бүгд нэгэн тэнгэр дор оршдогийг бэлгэдэж номин цэнхэр өнгөтэй, тугны зүүн талд Монгол Улсын газрын зураг дээр тус газрын чиг үүрэг зөвхөн Монгол Улсын газар нутгаар хязгаарлагдаагүйг илтгэж Улсын бүртгэлийн ерөнхий газрын бэлгэдлийг томоор байрлуулан, бэлгэдлийн баруун талд салбар нэгжийн нэрийг кирил бичгээр бичнэ. Тугны урт, өндөр нь 2:1 метр байна.

---oOo---



Текстийн хэмжээ фонд

- Газар хэлтсийн нэр: Tahoma 43 фондтой Жишээ нь: /АРХАНГАЙ АЙМАГ/
- Улсын бүртгэл: Times new roman 36 фондтой

Өнгөний СМҮК код

	C	M	Y	K
	1	5	85	0
	0	73	93	0
	72	13	6	2
	5	35	90	1